



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын даргын 2024 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/033/НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улаанбаатар хот
2025 он

Монгол Улсын Ерөнхий Аудиторын орлогч Я.Самбууням
Утас: 261885 Цахим хаяг: sambuunyamy@audit.gov.mn

Санхүү-нийцлийн аудитын газрын захирал,
Тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цогбаяр
Утас: 261628 Цахим хаяг: tsogbayara@audit.gov.mn

Ахлах аудитор: Ж.Бүжинханд
Утас: 261628 Цахим хаяг: bujinkhandj@audit.gov.mn

Аудитор: Д.Номингуа
Утас: 261628 Цахим хаяг: nominguad@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЦАГААТГАХ АЖЛЫГ УДИРДАН
ЗОХИОН БАЙГУУЛАХ УЛСЫН
КОМИССЫН ДАРГА Б.ПҮРЭВДОРЖ
ТАНАА

2025.04.25 № 1584

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын даргын төсвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, болон үр дүн, мөнгөн гүйлгээний тайлангууд, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдаагүй нийт 167.5 сая төгрөгийн зөрчил бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан, санхүүгийн тайлагналын “ангилал”, “толилуулга”, “нийцсэн ба зохистой байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. Тухайлбал:

- Бусдаар гүйцэтгүүлж, гэрээгээр хийгдсэн баримтат цуврал нэвтрүүлэг, түүхэн үйл явдлыг хүүхэд залуучуудад таниулах дүрст бичлэг зэрэг нийт 63.0 сая төгрөгийн биет бус хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй;
- Гэрээт ажилтны сарын цалинг нэмэгдүүлэх талаар гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулаагүй, эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр цалинг 1.5 сая төгрөгөөр тооцон 33.7 сая төгрөгийг илүү олгосон;
- Мөнгөн гүйлгээний тайланд нийт 21.3 сая төгрөгөөр зардлын эдийн засгийн ангиллыг буруу тайлагнасан;

Эдгээр зөрчил нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 41 дүгээр зүйлийн 41.2.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1, 67.2, Засгийн газрын 2023

оны 444 дүгээр тогтоолын хавсралт "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 3.4.10 заалтуудтай нийцэхгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Улсын комиссын дүрэм болон бусад хууль тогтоомжийн хүрээнд Иргэний хэргийн анхан шатны шүүхээс гаргасан шийдвэрийн дагуу тайлант онд 7,409.7 сая төгрөгийн нөхөх олговор олгохоор батлагдсанаас 108 иргэнд 4,320.0 сая төгрөг, 30 иргэнд 2,400.0 сая төгрөг, 10 иргэнд 410.0 сая төгрөг, 3 иргэнд 243.0 сая төгрөг, 1 иргэнд 20.0 сая төгрөг, 1 иргэнд 6.3 сая төгрөг, 3 иргэнд 3.0 сая төгрөг, нийт 156 иргэнд 7,402.3 сая төгрөгийн нөхөх олговрыг олгож, 7.4 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд Бүгд Найрамдах Солонгос Улсын Энхтайваны сантай байгуулсан хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд улс төрийн хэлмэгдүүлэлтийн түүх, өнөө үеийн хэлмэгдүүлэлтийн хандлага, хор уршиг, үр дагаврыг арилгах, соён гэгээрүүлэх нөлөөллийн чиглэлээр хэрэгжүүлж буй хамтын ажиллагааны чиглэлээр хийсэн айлчлал болон Бүгд Найрамдах Солонгос Улсын Азийн соёлын сангийн гишүүн орнуудын Олон улсын форумд оролцсон зэрэг арга хэмжээнд зориулж гадаад томилолт болон зочны зардалд нийт 51.6 сая төгрөг зарцуулсан байна.

Бусад асуудал

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс нь тайлант онд "Улс төрийн хэлмэгдүүлэлтийн учир шалтгаан, түүхэн нөхцөл байдал, түүхийг шинээр эргэн харах нь" сэдвээр сургалтыг үе шаттай явуулж, хэлмэгдүүлэлт түүний хор уршиг, хэлмэгдүүлэлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр их, дээд сургуулийн 2,500 гаруй оюутан сурагчид, офицер, ахлагч, хугацаат цэргийн албан хаагчдыг хамруулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



Д.ЗАГДЖАВ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	44,705,975.00	54,730,233.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
31100	Кассад байгаа бэлэн мөнгө	-	-
31200	Банканд байгаа бэлэн мөнгө	-	-
33	АВЛАГА	-	-
34	УРЬДЧИЛГАА	-	18,260,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	-	18,260,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	44,705,975.00	36,470,233.00
35400	Хангамжийн материал	44,705,975.00	36,470,233.00
35410	Бичиг хэргийн материал	4,301,700.00	3,825,200.00
35420	Аж ахуйн материал	1,965,500.00	1,045,500.00
35470	Бусад хангамжийн материал	38,438,775.00	31,599,533.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	28,720,745.50	44,687,319.28
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	28,720,745.50	44,687,319.28
39200	Биет хөрөнгө	26,169,162.13	42,960,152.58
39203	Авто-тээврийн хэрэгсэл	79,741,650.00	15,948,330.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(79,741,650.00)	(664,513.75)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	30,828,846.00	26,011,246.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(19,261,906.37)	(14,806,092.16)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	18,392,290.00	14,147,890.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(12,254,801.50)	(6,141,441.51)
39217	Ном	8,464,734.00	8,464,734.00
39300	Биет бус хөрөнгө	2,551,583.37	1,727,166.70
39301	Программ хангамж	10,257,000.00	3,526,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(7,705,416.63)	(1,798,833.30)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	73,426,720.50	99,417,552.28
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	73,426,720.50	99,417,552.28
51	Засгийн газрын хувь оролцоо	73,426,720.50	99,417,552.28
51100	Засгийн газрын оруулсан капитал	50,239,441.00	50,239,441.00
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	50,239,441.00	50,239,441.00
51200	Хуримтлагдсан үр дүн	23,187,279.50	49,178,111.28
51210	Өмнөх үеийн үр дүн	19,949,092.69	23,187,279.50
51220	Тайлант үеийн үр дүн	3,238,186.81	25,990,831.78
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	73,426,720.50	99,417,552.28

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	15,177,376,546.00	8,334,422,330.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,204,546.00	19,846,930.00
120	Нийтлэг татварын бус орлого	9,204,546.00	19,846,930.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,204,546.00	19,846,930.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	9,204,546.00	19,846,930.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	15,168,172,000.00	8,314,575,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	15,168,172,000.00	8,314,575,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	15,168,172,000.00	8,314,575,400.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	15,174,138,359.19	8,308,068,498.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ	15,174,138,359.19	8,308,068,498.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	787,159,681.74	858,234,311.02
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	336,039,894.70	384,542,715.65
210101	Үндсэн цалин	189,856,384.24	227,988,928.68
210102	Нэмэгдэл	90,635,554.46	83,932,441.42
210103	Унаа хоолны хөнгөлөлт	23,773,000.00	43,119,000.00
210104	Урамшуулал	31,774,956.00	29,502,345.55
210105	Гэрээт ажлын хөлс	-	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,829,192.26	45,373,800.00
210201	Тэтгэврийн даатгал	24,525,692.26	30,854,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,950,900.00	3,629,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,160,900.00	1,990,739.88
210204	Ажилгүйдлийн даатгал	590,100.00	1,639,060.12
210205	Эрүүл мэндийн даатгал	5,601,600.00	7,259,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,774,100.00	41,204,000.00
210304	Байрны түрээс	37,774,100.00	41,204,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,674,004.40	38,078,561.55
210401	Бичиг хэрэг	4,550,600.00	5,890,400.00
210402	Тээвэр, шатахуун	4,940,200.00	6,400,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,949,204.40	3,870,599.55
210404	Ном, хэвлэл	6,770,000.00	5,100,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,464,000.00	11,302,496.00
210408	Бараа материал акталсны зардал	-	5,515,066.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	8,922,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	2,903,500.00
210604	Урсгал засвар	-	6,019,000.00
2107	Томилолт, зочны зардал	62,869,600.00	69,089,597.00
210701	Гадаад албан томилолт	48,000,000.00	41,726,000.00
210702	Дотоод албан томилолт	14,869,600.00	17,460,460.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	9,903,137.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	273,272,923.45	236,642,785.60
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	269,540,803.45	227,188,285.60

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын даргын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,732,120.00	9,454,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,699,966.93	34,380,351.22
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	731,600.00	9,070,595.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,243,000.00	14,140,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	6,725,366.93	11,169,756.22
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,386,978,677.45	7,450,197,187.20
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,386,235,490.00	7,426,168,800.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	6,000,000.00	23,868,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	14,299,973,490.00	7,402,300,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	80,262,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	743,187.45	24,028,387.20
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	743,187.45	24,028,387.20
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	3,238,186.81	25,990,831.78
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	3,238,186.81	25,990,831.78

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	50,239,441.00	831,770.00	19,117,322.69	70,188,533.69
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	831,770.00	831,770.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	50,239,441.00	831,770.00	19,949,092.69	71,020,303.69
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	(831,770.00)	-	(831,770.00)
Тайлант үеийн үр дүн	-	-	3,238,186.81	3,238,186.81
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	50,239,441.00	-	23,187,279.50	73,426,720.50
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	50,239,441.00	-	23,187,279.50	73,426,720.50
Тайлант үеийн үр дүн	-	-	25,990,831.78	25,990,831.78
2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	50,239,441.00	-	49,178,111.28	99,417,552.28

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	15,168,172,000.00	8,314,575,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	15,168,172,000.00	8,314,575,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	15,168,172,000.00	8,314,575,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	15,168,172,000.00	8,314,575,400.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	15,168,191,600.00	8,307,286,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	15,168,191,600.00	8,307,286,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	781,212,922.55	857,088,812.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	336,039,894.70	384,542,715.65
210101	Үндсэн цалин	189,856,384.24	227,988,928.68
210102	Нэмэгдэл	90,635,554.46	83,932,441.42
210103	Унаа хоолны хөнгөлөлт	23,773,000.00	43,119,000.00
210104	Урамшуулал	31,774,956.00	29,502,345.55
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,635,800.00	45,373,800.00
210201	Тэтгэврийн даатгал	24,332,300.00	30,854,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,950,900.00	3,629,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,160,900.00	1,814,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	590,100.00	1,814,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,601,600.00	7,259,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,774,100.00	41,204,000.00
210304	Байрны түрээс	37,774,100.00	41,204,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,248,004.40	31,282,619.55
210401	Бичиг хэрэг	5,356,100.00	5,003,900.00
210402	Тээвэр, шатахуун	4,940,200.00	5,400,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,949,204.40	5,290,599.55
210404	Ном, хэвлэл	6,770,000.00	7,260,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,232,500.00	8,328,120.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	9,318,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	3,299,500.00
210604	Урсгал засвар	-	6,019,000.00
2107	Томилолт, зочны зардал	62,869,600.00	69,089,597.00
210701	Гадаад албан томилолт	48,000,000.00	41,726,000.00
210702	Дотоод албан томилолт	14,869,600.00	17,460,460.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	9,903,137.00

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын даргын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	271,670,923.45	253,066,985.60
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	260,428,803.45	243,222,285.60
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11,242,120.00	9,844,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,974,600.00	23,210,595.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	731,600.00	9,070,595.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,243,000.00	14,140,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,386,978,677.45	7,450,197,187.20
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,386,235,490.00	7,426,168,800.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	6,000,000.00	23,868,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	14,299,973,490.00	7,402,300,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	80,262,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	743,187.45	24,028,387.20
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	743,187.45	24,028,387.20
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	(19,600.00)	7,289,400.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	-	7,289,400.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	7,289,400.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	7,289,400.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	7,289,400.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-	(7,289,400.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(19,600.00)	-
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	19,600.00	-
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,314,575,400.00	8,290,547,012.80	24,028,387.20	99.7
УРСГАЛ ЗАРДАЛ	8,314,575,400.00	8,290,547,012.80	24,028,387.20	99.7
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	877,069,800.00	864,378,212.80	12,691,587.20	98.6
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	389,290,700.00	384,542,715.65	4,747,984.35	98.8
Үндсэн цалин	250,040,100.00	227,988,928.68	22,051,171.32	91.2
Нэмэгдэл	83,944,200.00	83,932,441.42	11,758.58	100.0
Унаа хоолны хөнгөлөлт	26,114,200.00	43,119,000.00	(17,004,800.00)	165.1
Урамшуулал	29,192,200.00	29,502,345.55	(310,145.55)	101.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,373,800.00	45,373,800.00	-	100.0
Тэтгэврийн даатгал	30,854,200.00	30,854,200.00	-	100.0
Тэтгэмжийн даатгал	3,629,900.00	3,629,900.00	-	100.0
ҮОМШӨ-ний даатгал	1,814,900.00	1,814,900.00	-	100.0
Ажилгүйдлийн даатгал	1,814,900.00	1,814,900.00	-	100.0
Эрүүл мэндийн даатгал	7,259,900.00	7,259,900.00	-	100.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,448,300.00	41,204,000.00	4,244,300.00	90.7
Байрны түрээс	45,448,300.00	41,204,000.00	4,244,300.00	90.7
Хангамж, бараа материалын зардал	34,041,200.00	31,282,619.55	2,758,580.45	91.9
Бичиг хэрэг	7,220,200.00	5,003,900.00	2,216,300.00	69.3
Тээвэр, шатахуун	6,726,200.00	5,400,000.00	1,326,200.00	80.3
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,322,800.00	5,290,599.55	3,032,200.45	63.6
Ном, хэвлэл	7,848,000.00	7,260,000.00	588,000.00	92.5
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,924,000.00	8,328,120.00	(4,404,120.00)	212.2
Эд хогшил, урсгал засварын зардал	15,887,300.00	15,758,000.00	129,300.00	99.2
Багаж, техник, хэрэгсэл	9,810,000.00	9,739,000.00	71,000.00	99.3
Урсгал засвар	6,077,300.00	6,019,000.00	58,300.00	99.0
Томилолт, зочны зардал	69,176,300.00	69,089,597.00	86,703.00	99.9
Гадаад албан томилолт	41,726,000.00	41,726,000.00	-	100.0
Дотоод албан томилолт	17,546,300.00	17,460,460.00	85,840.00	99.5
Зочин төлөөлөгч хүлээн авах	9,904,000.00	9,903,137.00	863.00	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	254,327,600.00	253,916,885.60	410,714.40	99.8
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	243,298,700.00	243,222,285.60	76,414.40	100.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11,028,900.00	10,694,600.00	334,300.00	97.0
Бараа үйлчилгээний бусад зардал	23,524,600.00	23,210,595.00	314,005.00	98.7
Бараа үйлчилгээний бусад зардал	9,221,400.00	9,070,595.00	150,805.00	98.4
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,303,200.00	14,140,000.00	163,200.00	98.9
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,437,505,600.00	7,426,168,800.00	11,336,800.00	99.8

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын даргын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Бусад урсгал шилжүүлэг	7,437,505,600.00	7,426,168,800.00	11,336,800.00	99.8
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	27,825,600.00	23,868,800.00	3,956,800.00	85.8
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	7,409,680,000.00	7,402,300,000.00	7,380,000.00	99.9
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	8,314,575,400.00	8,290,547,012.80	24,028,387.20	99.7
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	8,314,575,400.00	8,290,547,012.80	24,028,387.20	99.7
Улсын төсвөөс санхүүжих	8,314,575,400.00	8,290,547,012.80	24,028,387.20	99.7
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
Төсвийн байгууллага	1	1	-	100.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	11	11	-	100.0
Удирдах ажилтан	1	1	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	6	6	-	100.0
Үйлчлэх ажилтан	4	4	-	100.0
Гэрээт ажилтан	-	-	-	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Аудитаар нийт 190.9 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 23.4 сая төгрөгийн зөрчлийг залруулж, 75.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 албан шаардлагыг хүргүүлж, 91.9 сая төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

Аудитаар нийт 23.4 сая төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн. алдаа илэрснээс аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.

3.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							тоо	Дүн	тоо	Дүн		
2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Санхүүгийн тайланд бараа, ажил үйлчилгээний төлбөрт урьдчилж төлсөн 18.3 сая төгрөгийг тайлант үеийн зардлаар тайлагнасан;	1	18.3			1	18.3	1	18.3				
Үндсэн хөрөнгийн дансанд 2 ширхэг 5.0 сая төгрөгийн таблетыг программ хангамжаар, 0.1 сая төгрөгийн НББ-ын программыг машин тоног төхөөрөмжөөр тайлагнасан.	1	5.1			1	5.1	1	5.1				
Дүн	2	23.4	-	-	2	23.4	2	23.4	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой нийт 167.5 сая төгрөгийн зөрчил илэрснээс 75.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах 5 албан шаардлагыг хүргүүлж, 91.9 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгсөн.

3.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилүүлсэн	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын нарийн бичгийн	1	2.2			1	2.2						

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын даргын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

даргын 2024 оны А/33 дугаар тушаалыг үндэслэн "Л.Лааган " гэх номыг хэвлүүлэхээр "Бит пресс" ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээг 2024 оны 12 дугаар сарын 23-нд байгуулж, гэрээний үнийн дүн 2.2 сая төгрөгийг анхан шатны баримтын шаардлага хангаагүй /номыг хүлээн авсан баримтгүй/ байхад олгосон байна. Тухайлбал: Уг номыг хэвлэж бэлэн болоогүй байхад 2024 оны 12 дугаар сарын 23-ны өдөр бараа материалын дансанд орлогоор бүртгэж, 12 дугаар сарын 26-нд 280 ширхэг номыг данснаас хасалт хийсэн, уг номыг 2025 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр хүлээн авч акт үйлдсэн байна;												
Батлагдсан төсвөөс бэлэг дурсгалд 4.0 сая төгрөг, 34 жилийн ойд зориулсан дэвтэр, батламж, лого, бэлэг дурсгалын зоосонд нийт 6.4 сая төгрөг нийт 10.4 сая төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардлаас гаргаж, төсвийг үр ашиггүй зарцуулсан байна;	1	10.4			1	10.4						
Нарийн бичгийн дарга байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй автомашиныг хот дотор ашиглаж, анхан шатны бүрдэл дутуу баримтаар 6.4 сая төгрөгийн шатахууныг зарцуулсан. Жолоочийн замын хуудас дээрх тооцоолол нь шатахуун зарцуулалтын жишиг нормыг баримтлаагүй;	1	6.4			1	6.4						
Тайлант онд 23.0 сая төгрөгийн контент бүтээлгэх ажлын худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй, төсөвт өртгийг хувааж иргэн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулан шууд худалдан авалт хийсэн байна;	1	23.0			1	23.0						
Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын дарга болон Тагнуулын ерөнхий газрын дарга нарын 2021 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 2021/02 дугаартай хамтран ажиллах гэрээнд Тагнуулын ерөнхий газрын Мөрдөн шалгах газарт нэмэлтээр 5 мөрдөгчийг ажиллуулан сарын цалинг 0.7	1	33.7			1	33.7						

**Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын даргын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

сая төгрөгөөр тооцож олгохоор заасан байна. Гэрээт ажилтны сарын цалинг нэмэгдүүлэх талаар гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулаагүй, эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр цалинг 1.5 сая төгрөгөөр тооцон 33.7 сая төгрөгийг илүү олгосон;												
Мөнгөн гүйлгээний тайланд нийт 21.3 сая төгрөгөөр зардлын эдийн засгийн ангиллыг буруу тайлагнасан. Тухайлбал: Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 7.4 сая төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 0.4 сая төгрөг, шуудан, холбоо, интернэтийн төлбөр зардлаас 1.0 сая төгрөг, ном,хэвлэл зардлаас 5.1 сая, багаж, техник, хэрэгсэл зардлаас 0.1 сая төгрөг, мэдээлэл, технологийн үйлчилгээ зардлаас 1.8 сая төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас 5.5 сая төгрөгөөс тус тус зарцуулсан;	1	21.3							1	21.3		
Ажилчидтай тогтвор суурьшилтай ажиллах гэрээ байгуулалгүй, 2 албан хаагчид 7.6 сая төгрөгийн доктор, магистрын хөтөлбөрийн сургалтын төлбөрийн дэмжлэг олгосон;	1	7.6							1	7.6		
Бусдаар гүйцэтгүүлж, гэрээгээр хийгдсэн баримтат цуврал нэвтрүүлэг, түүхэн үйл явдлыг хүүхэд залуучуудад таниулах дүрст бичлэг зэрэг нийт 63.0 сая төгрөгийн биет бус хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй.	1	63.0							1	63.0		
Дүн	8	167.5	-	-	5	75.6	-	-	3	91.9	-	-

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн аудиттай холбоотой нийт 4,188.8 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 4,188.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлагыг хүргүүлсэн.

3.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны цахим системд төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой нийт 28.4 сая төгрөгийн 4 тушаал, шийдвэрийг мэдээлээгүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 2,842.0 сая төгрөгийн 13 гүйлгээг, 980.3 сая төгрөгийн зарлагын 33 гүйлгээг, 268.1 сая төгрөгийн 34 тушаал, шийдвэрийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	1	4,118.8			1	4,118.8		
Дүн	1	4,188.8	-	-	1	4,118.8	-	-